

Дуу



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/777

Улаанбаатар хот

Цэргийн дүрэмт хувцас өмсөх
дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.15 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 01 дүгээр зарлигаар баталсан “Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны “Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар батлах тухай” 141 дүгээр зарлиг, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын “Ажлын хэсэг байгуулж, ажиллуулах тухай” 2024 оны А/606 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгээс боловсруулсан саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.
2. Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрмийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга (бригадын генерал Ж.Өсөхбаяр), Хил хамгаалах Ерөнхий газар (хошууч генерал Х.Лхагвасүрэн), Онцгой байдлын Ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар (хурандаа Б.Нандинболор), Тагнуулын Ерөнхий газар (хошууч генерал П.Одонбаатар), Төрийн тусгай хамгаалалтын газар (бригадын генерал Л.Алтангэрэл), Дотоодын цэргийн штабын дарга (бригадын генерал Р.Чингис) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны А/167 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.
4. Дүрмийг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Захиргааны удирдлагын газар (хурандаа Д.Дашзэвэг)-т хариуцуулсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Материал, техникийн газар (хурандаа Б.Түвшинтөр), Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (хурандаа С.Баяр-Очир)-т тус тус даалгасугай.

ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

С. ГАНБЯМБА
2024.12.20

Tushaal-2024

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын
2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
А/777 дугаар тушаалын хавсралт



ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЦАС ӨМСӨХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм (цаашид “дүрэм” гэх)-ийн зорилго нь цэргийн жинхэнэ алба хаагч (цаашид “алба хаагч” гэх), цэргийн бэлтгэл үүрэгтэн (цаашид “бэлтгэл үүрэгтэн” гэх)-ий Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталдсан цэргийн дүрэмт хувцсыг өмсөх, цол, ялгах тэмдгийг хэрэглэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тагнуулын байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад энэ дүрмийг дагаж мөрдөнө.

1.3. Цэргийн дүрэмт хувцас нь төрийн өмч бөгөөд цэргийн эд хөрөнгө мөн.

1.4. Цэргийн дүрэмт хувцас гэж алба хаагч, бэлтгэл үүрэгтэн хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх үедээ өмсөж хэрэглэх зориулалттай эрх бүхий албан тушаалтны баталсан загварын нормт хангалтын хувцас, хэрэглэлийг хэлнэ.

1.5. Цэргийн дүрэмт хувцас нь албаны, ёслолын, хээрийн дүрэмт хувцас гэсэн төрөлтэй байх бөгөөд өмсөж хэрэглэх цаг улирлаас хамааран дулааны, хүйтний улирлын болон сэрүүний үеийн гэж ангилна. Өмсөх кодыг дүрмийн хавсралтад тусгав.


1.5.1. “Албаны дүрэмт хувцас” гэж алба хаагч албаны үүрэг гүйцэтгэх үед өдөр тутам өмсөж хэрэглэх зориулалт бүхий хувцас, хэрэглэлийг;

1.5.2. “Ёслолын дүрэмт хувцас” гэж алба хаагч, бэлтгэл үүрэгтэн төрийн болон цэргийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох үед өмсөж хэрэглэх зориулалт бүхий хувцас, хэрэглэлийг;

1.5.3. “Хээрийн дүрэмт хувцас” гэж алба хаагч хээрийн дадлага, сургуульд оролцох, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны болон тусгай үүрэг гүйцэтгэх, бэлтгэл үүрэгтэн цэргийн дайчилгааны цугларалт, сургуульд оролцох үед өмсөж хэрэглэх зориулалт бүхий хувцас, хэрэглэлийг хэлнэ.

1.6 Бэлтгэл үүрэгтэн алба хаах хугацаандаа хэрэглэж байсан загварын цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийг цэргийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон дайчилгаатай сургууль, цугларалтад оролцох үед өмсөж хэрэглэж болно.

1.7. Алба хаагчийн хүйтний болон дулааны улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэх хугацааг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар тогтоох ба дээрх улирлын завсрын сэрүүний үед хувцас, хэрэглэлийг цаг улирлын байдалд тохируулан энэ дүрэмд заасны дагуу өмсөж хэрэглэнэ.



1.8 Төрийн цэргийн бусад байгууллагын алба хаагчийн хүйтний болон дулааны улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэх хугацааг ЗХЖШ-ын даргын тушаалыг үндэслэн гүйцэтгэх үүргийн онцлог, бусад хүчин зүйлсийг харгалзан тухайн байгууллагын даргын тушаалаар тогтоож болно.

1.9 Цэргийн дүрэмт хувцаснаас бусад тусгай зориулалтын болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийг асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журам, зааврын дагуу өмсөж хэрэглэнэ.

Хоёр. Албаны дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх

2.1. Дулааны улиралд өмсөж хэрэглэх (Хүснэгт 1):

2.1.1. Албаны китель, өмд, юбка: Албаны малгай, албаны цамц (урт, богино ханцуйтай), албаны зангиа, өмдний тэлээ, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Гадаад улсад томилолтоор ажиллах, суралцах үед болон захирагч (дарга)-ийн шийдвэрээр майхан малгай, берет малгайтай хослуулан өмсөж болно. Захирагч (дарга) тогтоож өгөөгүйгээс бусад үед эмэгтэй алба хаагч юбка өмсөнө.

2.1.2. Албаны хүрэм: Майхан малгай эсхүл берет малгай, футболк, албаны өмд, өмдний тэлээ, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Албаны хүрмийн цахилгааныг энгэрийн залгаа оёдлоос дээш 50 мм хэмжээтэй татна. Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед өмсөнө. Захирагч (дарга)-ийн шийдвэрээр нэгдсэн ажиллагаанд өмсөж болно. Захирагч (дарга) тогтоож өгөөгүйгээс бусад үед эмэгтэй алба хаагч юбка өмсөнө.

2.1.3. Албаны цамц (богино ханцуйтай): Албаны малгай, албаны өмд, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Энэ тохиолдолд албаны зангиа зүүхгүй, цамцны дээд талын нэг дэх товчийг тайлж өмсөнө. Захирагч (дарга)-ийн шийдвэрээр майхан малгай, берет малгай, саравчтай малгайтай хослуулан өмсөж болно.

2.1.4. Албаны цамц (урт ханцуйтай): Албаны китель өмссөн үед өмсөх ба ханцуйд ялгах тэмдэг болон чимэг хэрэглэл зүүхгүй, албаны зангиа, зангианы хавчаартай өмсөнө. Китель өмсөөгүй үед цамцны мөрдэс, албаны зангиатай өмсөнө.

2.1.5. Захтай футболк: Саравчтай малгай, албаны өмд, юбкайтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед өмсөж хэрэглэнэ. Нэгдсэн ажиллагааны үед захирагч (дарга)-ийн шийдвэрээр өмсөж болно.

2.1.6. Албаны малгай: Албаны хүрэм, захтай футболк өмсөхөөс бусад тохиолдолд өмсөх ба саравчны үзүүрийг хөмсөгний түвшинд байхаар тохируулан өмсөнө.

2.1.7. Берет малгай: Албаны хувцастай өмссөн тохиолдолд малгайн тэмдгийг зүүн хөмсөгний дээд талд голлуулж, малгайны доод хүрээг хөмсөгнөөс 10 мм дээш, баруун гар тал руу дарж өмсөнө.



2.1.8. Саравчтай малгай: Захтай футболк, албаны цамц (богино ханцуйтай) -тай хослуулан өмсөнө. Малгайны саравчны үзүүрийг хөмсөгний түвшинд байхаар тохируулан өмсөнө.

2.1.9. Майхан малгай: Албаны хүрэм, захтай футболк, албаны цамц (богино ханцуйтай)-тай хослуулан өмсөнө. Малгайн тэмдгийг дух голлуулан, баруун талруу үл ялиг хазгай байдлаар, малгайны доод ирмэгийг баруун хөмсөгнөөс 10 мм дээр өмсөнө. Нэгдсэн ажиллагааны үед захирагч (дарга)-ийн шийдвэрээр өмсөж болно.

2.1.10. Футболк: Албаны хүрэм өмссөн үед футболк өмсөнө.

2.1.11. Албаны зангиа: Албаны (урт ханцуйтай) цамц өмссөн үед зүүж, цамцны дээрээс 4-5 дахь товчны дундуур зангианы хавчаараар хавчина.

2.1.12. Зуны гутал: Албаны хувцас өмссөн үед өмсөнө. Дээд офицер гялгар (лак) арьсан, офицер, ахлагч нар арьсан материалтай, хээ чимэг, тоноггүй, гоёлын оёдолгүй, хар өнгийн гутал өмсөнө. Эрэгтэй цэргийн албан хаагчийн гутлын өсгийн өндөр 25-30 мм, эмэгтэй алба хаагчийн өсгийн өндөр 40-50 мм байна.

2.1.13. Өмдний тэлээ: Албаны өмд, юбка өмссөн үед хэрэглэнэ.

2.1.14. Даавуун оймс: Алба хаагч хар өнгийн оймс өмсөнө.

2.1.15. Борооны цув: Албаны дүрэмт хувцас дээр өмсөж хэрэглэнэ.

2.1.16. Эмэгтэй алба хаагч дулааны улиралд биеийн өнгөтэй, хээ чимэглэлгүй нимгэн оймс (трико) өмсөнө.

2.2. Сэрүүний үед өмсөж хэрэглэх (Хүснэгт 1):

2.2.1. Гурвалжин захтай майк (нэхмэл): Албаны китель өмссөн үед өмсөнө.


2.2.2. Ноосон цамц (сүлжмэл): Албаны хүрэм өмссөн үед цамцны мөрдэстэй өмсөнө. Мөрдэстэй тохиолдолд албаны өрөөнд албаны өмд, юбкайтай хослуулан өмсөж болно.

2.2.3. Хавар, намрын пальто: Дээд офицер албаны хувцас, хэрэглэл дээр албаны малгай, хүзүүний ороолт, савхин бээлийтэй өмсөнө. Энэ тохиолдолд дээд офицер албаны мөрдэс зүүж хэрэглэнэ.

2.2.4. Савхин дээл: Албаны хувцас, хэрэглэл дээр цегейк (каракуль) захгүй, албаны малгай, хүзүүний ороолт, савхин бээлийтэй өмсөнө. Энэ тохиолдолд дээд офицер албаны мөрдэс, офицер, ахлагч нар савхин мөрдэс зүүж хэрэглэнэ.

2.2.5. Албаны дулаан хүрэм: Сэрүүний үед албаны хувцас, хэрэглэл дээр юүдэн, доторгүйгээр албаны малгай, савхин бээлий, албаны мөрдэстэй өмсөнө. Захирагч (дарга)-ийн шийдвэрээр берет малгайтай хослуулан өмсөж болно.

2.2.6. Савхин бээлий: Хавар намрын пальто, савхин дээл, албаны дулаан хүрэм өмссөн үед хэрэглэнэ.



2.2.7. Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл): Хавар, намрын пальто, савхин дээлийн дотор талаар, эрэгтэй алба хаагч ороолтын баруун талыг зүүн талаар, эмэгтэй алба хаагч зүүн талыг баруун талаар дарж зүүнэ.

2.2.8. Эмэгтэй алба хаагч сэрүүний үед хар өнгийн хээ чимэглэлгүй ноосон өмд (трико) өмсөнө.

2.3. Хүйтний улиралд өмсөж хэрэглэх (Хүснэгт 2):

2.3.1. Өвлийн малгай: Малгайны доод ирмэгийг хөмсөгнөөс дээш 10 мм зайд өмсөнө. Хэт хүйтэн үед өвлийн малгайг буулгаж өмсөх тохиолдолд бүчийг эрүүн доогуур, эсхүл малгайн ард бүчилнэ.

2.3.2. Өвлийн пальто: Дээд офицер албаны китель, өмд, юбка дээр өвлийн малгай, албаны мөрдэс, хүзүүний ороолт, савхин бээлий, өвлийн гуталтай өмсөнө.

2.3.3. Савхин дээл: Албаны китель, өмд, юбка дээр цегейк (каракуль) захтайгаар өвлийн малгай, хүзүүний ороолт, савхин бээлий, өвлийн гуталтай өмсөнө. Дээд офицер албаны мөрдэс, офицер, ахлагч нар савхин мөрдэс зүүж хэрэглэнэ.

2.3.4. Албаны дулаан хүрэм: Хүйтний улиралд албаны хувцас, хэрэглэл дээр юдэн, дотортойгоор өвлийн малгай, савхин бээлий, өвлийн гутал, албаны мөрдэстэй өмсөнө.

2.3.5. Гурвалжин захтай майк (нэхмэл): Албаны китель өмссөн үед өмсөнө.

2.3.6. Ноосон цамц (сүлжмэл): Албаны хүрэм өмссөн үед цамцны мөрдэстэй өмсөнө. Мөрдэстэй тохиолдолд албаны өрөөнд албаны өмд, юбкатай хослуулан өмсөж болно.


2.3.7. Савхин бээлий: Өвлийн пальто, савхин дээл, албаны дулаан хүрэм өмссөн үед хэрэглэнэ.

2.3.8. Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл): Өвлийн пальто, савхин дээлийн дотор талаар, эрэгтэй алба хаагч ороолтын баруун талыг зүүн талаар, эмэгтэй алба хаагч зүүн талыг баруун талаар дарж зүүнэ.

2.3.9. Өвлийн гутал: Албаны хувцас өмссөн үед өмсөнө. Дээд офицер гялгар (лак) арьсан, офицер, ахлагч нар арьсан материалтай, хээ чимэг, тоноггүй гоёлын оёдолгүй, хар өнгийн өвлийн гутал өмсөнө. Эрэгтэй цэргийн алба хаагчийн гутлын түрий 180 мм-ээс багагүй, өсгийн өндөр 25-30 мм, эмэгтэй алба хаагчийн гутлын түрий 350 мм-ээс багагүй, өсгийн өндөр 50-60 мм байна.

2.3.10. Эмэгтэй алба хаагч хүйтний улиралд хар өнгийн ноосон өмд (трико) өмсөнө.

Гурав. Ёслолын дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх.



3.1. Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын бүрэлдэхүүн цэргийн тангараг өргөх, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, тэмдэглэлт ой, цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаанд ёслолын хувцас, хэрэглэлийг өмсөж, хэрэглэнэ.

3.2. Алба хаагч нь энэхүү дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаас гадна цэргийн сургууль, дамжаа төгсөх, цэргийн цол хүртэх, Төрийн одон, медаль, салбарын шагналаар шагнагдах, бэлтгэлээр чөлөөнд гарах хүндэтгэлийн ажиллагаанд өмсөж, хэрэглэнэ.

3.3. Ёслолын хувцсыг ёслол - жагсаалын, ёслол - амралтын байдлаар өмсөж хэрэглэх бөгөөд энэ дүрмийн 3.1, 3.2-т заасан үед ёслол-жагсаалын байдлаар, бусад үед ёслол-амралтын байдлаар өмсөж хэрэглэнэ.

3.4. Ёслол-жагсаалын байдлаар ёслолын хувцас өмссөн үед ёслолын малгай, ёслолын цамц, ёслолын зангиа, саан бүс, зуны гуталтай өмсөж, кителийн зүүн энгэрт төрийн болон салбарын одон, медаль, тэмдэг, баруун энгэрт нэрийн тэмдэг, сүүлд төгссөн сургуулийн тэмдэг зүүж хэрэглэнэ.

3.5. Ёслол-амралтын байдлаар ёслолын хувцас өмссөн үед ёслолын малгай, ёслолын цамц, ёслолын зангиа, зуны гуталтай өмсөж, саан бүс (Онцгой байдлын байгууллагаас бусад), саан зүүлт, бээлий хэрэглэхгүй, кителийн зүүн энгэрт одон, медалийн тууз, баруун энгэрт нэрийн тэмдэг, сүүлд төгссөн сургуулийн тэмдэг зүүж хэрэглэнэ. Энэ тохиолдолд дээд офицер албаны хувцасны мөрдэс зүүнэ.

3.6. Төрийн хүндэт харуул (ҮЖҮНХ), төрийн торгон цэрэг (морьт)-ийн бие бүрэлдэхүүн төрийн ёслолын ажиллагаанд төрийн ёслолын хүндэт харуулын болон торгон цэрэг (морьт)-ийн дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэнэ.

3.7. Дулааны улиралд өмсөж хэрэглэх (Хүснэгт 1):

3.7.1. Ёслолын китель, өмд, юбка: Ёслол-жагсаалын болон ёслол-амралтын байдлаар өмсөж хэрэглэнэ.

3.7.2. Ёслолын цамц (богино ханцуйтай): Ёслолын малгай, ёслолын өмд, зуны гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Энэ тохиолдолд ёслолын зангиа зүүхгүй, цамцны дээд талын нэг дэх товчийг тайлж өмсөнө.


3.7.3. Ёслолын цамц (урт ханцуйтай): Ёслолын китель өмссөн үед өмсөх ба ханцуйд ялгах тэмдэг болон чимэг хэрэглэл зүүхгүй, ёслолын зангиа, зангианы хавчаартай өмсөнө. Китель өмсөөгүй үед цамцны мөрдэс, ёслолын зангиа, зангианы хавчаар зүүнэ.

3.7.4. Ёслолын малгай: Ёслолын хувцас өмссөн үед саравчны үзүүрийг хөмсөгний түвшинд байхаар тохируулан өмсөнө.

3.7.5. Ёслолын зангиа: Ёслолын цамц (урт ханцуйтай) өмссөн үед зүүж, цамцны дээрээс 4-5 дахь товчны дунд зангианы хавчаараар хавчина.

3.7.6. Бээлий (цагаан): Ёслол-жагсаалын байдлаар өмсөх үед хэрэглэнэ.

3.7.7. Зуны гутал: Ёслолын дүрэмт хувцас өмссөн үед өмсөнө. Дээд офицер гялгар (лак) арьсан, офицер, ахлагч нар арьсан материалтай, хээ чимэг,



тоноггүй, гоёлын оёдолгүй, хар өнгийн гутал өмсөнө. Эрэгтэй алба хаагчийн гутлын өсгийн өндөр 25-30 мм, эмэгтэй алба хаагчийн өсгийн өндөр 40-50 мм байна.

3.7.8. Өмдний тэлээ: Ёслолын дүрэмт хувцас өмссөн үед хэрэглэнэ.

3.7.9. Саан бүс: Ёслол-жагсаалын байдлаар өмссөн үед ёслолын кителийн гадуур, доод талын 2 товчны дундуур, халаасны тагны дээд ирмэгт бүсний доод ирмэгийг тулган бүсэлж хэрэглэнэ.

3.7.10. Борооны цув: Ёслолын дүрэмт хувцас дээр өмсөж хэрэглэнэ.

3.7.11. Эмэгтэй алба хаагч дулааны улиралд биеийн өнгөтэй, хээ чимэглэлгүй нимгэн оймс (трико) өмсөнө.

3.7.12. Цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаанд хугацаат цэргийн алба хаагч оролцох үед захирагч (дарга)-ийн зөвшөөрлөөр саан зүүлт, бээлий, саан бүс зүүж хэрэглэж болно.

3.8. Сэрүүний үед өмсөж хэрэглэх (Хүснэгт 1):

3.8.1. Гурвалжин захтай майк (нэхмэл): Ёслолын китель өмссөн үед өмсөнө.

3.8.2. Хавар, намрын пальто: Дээд офицер ёслолын дүрэмт хувцас дээр ёслолын малгай, хүзүүний ороолт, савхин бээлийтэй өмсөнө. Энэ тохиолдолд дээд офицер албаны мөрдэс зүүж хэрэглэнэ.

3.8.3. Савхин дээл: Ёслолын дүрэмт хувцас дээр цегейк (каракуль) захгүй, ёслолын малгай, хүзүүний ороолт, савхин бээлийтэй өмсөнө. Энэ тохиолдолд дээд офицер албаны мөрдэс, офицер, ахлагч нар савхин мөрдэс зүүж хэрэглэнэ.

3.8.4. Савхин бээлий: Хавар намрын пальто, савхин дээл өмссөн үед хэрэглэнэ.


3.8.5. Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл): Хавар, намрын пальто, савхин дээлийн дотор талаар, эрэгтэй алба хаагч ороолтын баруун талыг зүүн талаар, эмэгтэй алба хаагч зүүн талыг баруун талаар дарж зүүнэ.

3.8.6. Эмэгтэй алба хаагч сэрүүний үед хар өнгийн хээ чимэглэлгүй ноосон өмд (трико) өмсөнө.

3.9. Хүйтний улиралд өмсөж хэрэглэх (Хүснэгт 2) :

3.9.1. Өвлийн малгай: Малгайны доод ирмэгийг хөмсөгнөөс дээш 10 мм зайд өмсөнө. Хэт хүйтэн үед өвлийн малгайг буулгаж өмсөх тохиолдолд бүчийг эрүүн доогуур, эсхүл малгайн ард бүчилнэ.

3.9.2. Өвлийн пальто: Дээд офицер ёслолын китель, өмд, юбка дээр өвлийн малгай, албаны мөрдэс, хүзүүний ороолт, савхин бээлий, өвлийн гуталтай өмсөнө.



3.9.3. Савхин дээл: Алба хаагч савхин дээлийг ёслолын китель, өмд, юбка дээр цегейк (каракуль) захтайгаар өвлийн малгай, хүзүүний ороолт, савхин бээлий, өвлийн гуталтай өмсөнө. Дээд офицер албаны мөрдэс, офицер ахлагч нар савхин мөрдэс зүүж хэрэглэнэ.

3.9.4. Гурвалжин захтай майк (нэхмэл): Ёслолын китель өмссөн үед өмсөнө.

3.9.5. Савхин бээлий: Өвлийн пальто, савхин дээл өмссөн үед хэрэглэнэ.

3.9.6. Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл): Өвлийн пальто, савхин дээлийн дотор талаар, эрэгтэй алба хаагч ороолтын баруун талыг зүүн талаар, эмэгтэй алба хаагч зүүн талыг баруун талаар дарж зүүнэ.

3.9.7. Өвлийн гутал: Ёслолын дүрэмт хувцас өмссөн үед өмсөнө. Дээд офицер гялгар (лак) арьсан, офицер, ахлагч нар арьсан материалтай, хээ чимэг, тоноггүй, гоёлын оёдолгүй, хар өнгийн өвлийн гутал өмсөнө. Эрэгтэй цэргийн алба хаагчийн гутлын түрий 180 мм-ээс багагүй, өсгийн өндөр 25-30 мм, эмэгтэй алба хаагчийн гутлын түрий 350 мм-ээс багагүй, өсгийн өндөр 50-60 мм байна.

3.9.8. Эмэгтэй алба хаагч хүйтний улиралд хар өнгийн хээ чимэглэлгүй ноосон өмд (трико) өмсөнө.

Дөрөв. Хээрийн дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх

4.1. Алба хаагч хээрийн дадлага, сургуульд оролцох, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны болон тусгай үүрэг гүйцэтгэх, анги, байгууллагыг шалгах, шалган туслах ажлаар явах, бэлтгэл үүрэгтэн цэргийн дайчилгааны цугларалт, сургуульд оролцох үед өмсөж хэрэглэнэ.

4.2. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч цэргийн сургалт бэлтгэл, өдөр тутмын үйл ажиллагаанд хээрийн дүрэмт хувцсыг өмсөнө.

4.3. Цэргийн сургуулийн сонсогч, оюутан цэрэг хээрийн дүрэмт хувцсыг өмсөж болно.


4.4. Дулааны улиралд өмсөж хэрэглэх (Хүснэгт 1):

4.4.1. Хээрийн китель, өмд: Хээрийн малгай, футболк, хээрийн дотуур цамц, тактикийн бүс, хээрийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Алба хаагч өмдний шуумгийг гутлын түрийний гадуур, хугацаат цэргийн алба хаагч гутлын түрийний дотор хийж өмсөнө. Захирагч (дарга)-ийн шийдвэрээр берет малгайтай хослуулан өмсөж болно.

4.4.2. Футболк: Хээрийн хувцас өмсөх бүх (захтай футболк өмссөнөөс бусад) тохиолдолд өмсөнө.

4.4.3. Захтай футболк: Хээрийн малгай, хээрийн өмд, хээрийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

4.4.4. Хээрийн дотуур цамц: Хээрийн зуны кителийн дотор өмсөх ба тусгай зориулалтын хамгаалах хэрэгсэл өмссөн үед дангаар өмсөж болно.



4.4.5. Ноосон цамц (сүлжмэл): Цаг агаарын нөхцөлд байдалд тохируулан хээрийн зуны китель дотор өмсөж болно.

4.4.6. Хээрийн малгай: Хээрийн хувцас өмссөн бүх тохиолдолд өмсөнө.

4.4.7. Берет малгай: Хээрийн хувцастай өмссөн тохиолдолд малгайн тэмдгийг зүүн хөмсөгний дээд талд голлуулж, малгайны доод хүрээг хөмсөгнөөс 10 мм дээш, баруун гар тал руу дарж өмсөнө.

4.4.8. Тактикийн бүс: Алба хаагч, бэлтгэл үүрэгтэн хээрийн хувцас, хэрэглэл өмссөн үед өмдтэй хослуулан хэрэглэнэ. Тагнуул болон Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын алба хаагч албаны хувцастай харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ бүсэнд бууны гэр болон бусад тусгай хэрэгсэл зүүх үед албаны китель, хүрэм, хүйтний улиралд албаны дулаан хүрмийн дотор талаар бүсэлнэ.

4.4.9. Даавуун оймс: Хар өнгийн оймс өмсөнө.

4.4.10. Хээрийн гутал: Хээрийн хувцас өмсөх бүх тохиолдолд өмсөнө.

4.4.11. Нөмрөг цув: Хээрийн хувцас дээр өмсөнө.

4.5. Сэрүүний үед өмсөж хэрэглэх (Хүснэгт 1):

4.5.1. Хээрийн хүрэм, өмд: Хээрийн малгай, хээрийн китель, хээрийн дулаан цамц, тактикийн бүс, хээрийн гутал, савхи (тактик)-н бээлийтэй өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Өмдний шуумгийг гутлын түрийний гадуур тавьж өмсөнө. Захирагч (дарга)-ийн шийдвэрээр ноосон малгай, хоолойвчтой хослуулан өмсөж болно.

4.5.2. Хээрийн дулаан цамц: Хээрийн малгай, өмд, гуталтайгаар хээрийн хүрэм, китель дотор өмсөнө. Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед дангаар нь өмсөж болох ба чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

4.5.3. Ноосон цамц (сүлжмэл): Хээрийн китель өмссөн үед хээрийн мөрдэстэй өмсөнө. Мөрдэстэй тохиолдолд албаны өрөөнд дангаар нь хээрийн өмдтэй хослуулан өмсөж болно.

4.5.4. Берет малгай: Хээрийн хүрэм, өмдтэй өмссөн тохиолдолд малгайн тэмдгийг зүүн хөмсөгний дээд талд голлуулж, малгайны доод хүрээг хөмсөгнөөс 10 мм дээш, баруун гар тал руу дарж өмсөнө.

4.5.5. Савхин бээлий (тактикийн бээлий): Хээрийн хүрэм, өмд өмссөн үед хэрэглэнэ.

4.6. Хүйтний улиралд өмсөж хэрэглэх (Хүснэгт 2):

4.6.1. Өвлийн малгай: Хугацаат цэргийн алба хаагч өмсөж хэрэглэнэ.

4.6.2. Ноосон малгай, хоолойвч: Ноосон малгайг хээрийн хувцас хэрэглэл өмсөх бүх тохиолдолд өмсөнө. Малгайн гол хэсэгт хатгамал соёмбо тэмдэгтэй



байна. Хоолойвчийг цаг агаарын нөхцөл байдалд тохируулан зүүж хэрэглэнэ. Хугацаат цэргийн алба хаагч цаг агаарын нөхцөл байдалд тохируулан захирагч (дарга)-ийн шийдвэрээр өмсөж болно.

4.6.3. Хээрийн дулаан цамц: Өвлийн хээрийн хүрэм, китель дотор өмсөнө. Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед дангаар нь өмсөж болох ба чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

4.6.4. Өвлийн хээрийн хүрэм, өмд: Ноосон малгай, хоолойвч, савхин бээлий, хээрийн дулаан цамц эсхүл хээрийн кительтэй өмсөнө. Өмдний шуумгийг гутлын түрийний гадуур тавьж өмсөнө.

4.6.5. Хээрийн өвлийн хүрэм: Хугацаат цэргийн алба хаагч өвлийн малгай эсхүл ноосон малгай, хоолойвч, дотортой китель, өмд, тактикийн бүс, ноосон болон хөвөнтэй бээлий, өвлийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

4.6.6. Дотортой китель, өмд: Хугацаат цэргийн алба хаагч хээрийн өвлийн хүрэм дотор тактикийн бүсгүйгээр өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Хээрийн өвлийн хүрэм өмсөөгүй тохиолдолд дотортой кителийн гадуур тактикийн бүс зүүнэ.

4.6.7. Ноосон цамц (сүлжмэл): Хээрийн китель өмссөн үед хээрийн мөрдэстэй өмсөнө. Мөрдэстэй тохиолдолд албаны өрөөнд дангаар нь хээрийн өмдтэй хослуулан өмсөж болно. Хугацаат цэргийн алба хаагч ноосон цамц (сүлжмэл) -ийг дотортой кителийн дотор өмсөнө.

4.6.8. Савхин бээлий: Өвлийн хээрийн хүрэм, өмд өмссөн үед өмсөнө.

4.6.9. Ноосон бээлий: Хугацаат цэргийн алба хаагч өмсөнө.

4.6.10. Хээрийн гутал: Хээрийн хувцас өмсөх бүх тохиолдолд өмсөнө.

4.6.11. Өвлийн гутал: Хугацаат цэргийн алба хаагч хагас түрийтэй хар өнгийн гутал өмсөх ба гутлын үдээсийг чангалж үдэн, түрийний дотор талд хийнэ.


4.6.12. Ноосон оймс: Алба хаагч хар өнгийн оймс өмсөнө.

Тав. Чимэг хэрэглэл зүүж хэрэглэх

5.1. Малгайн тэмдэг: Албаны болон ёслолын малгай, хугацаат цэргийн алба хаагчийн малгайны цохны төвд, өвлийн малгайны цохны доод ирмэгээс дээш 25 мм-т тэмдгийн доод ирмэг байхаар зүүнэ.

5.2. Малгайн сагалдарга: Албаны болон ёслолын малгайны баруун, зүүн талын товчинд бэхлэгдэж, малгайн тэмдгийн доод ирмэгт байхаар тогтооно.

5.3. Агаарын цэргийн малгайн ялгах тэмдэг: Нисгэгч, нисэхийн инженер, техникийн бүрэлдэхүүн, шүхэрчид албаны болон ёслолын малгайны цохны дээд хэсэгт малгайн дээд хүрээнээс доош 3 мм зайд зүүнэ.



5.4. Захны таних тэмдэг (металл): Албаны китель, албаны хүрмийн захны бартааны дээд хэсэгт зүүнэ. Таних тэмдгийн төвөөс захны өнцөг хүртэлх зай 25 мм байна.

5.5. Саан зүүлт: Саан зүүлтийн дээд тогтоогчийг ёслолын кителийн баруун мөрний оёдолд тулгаж мөрдэсний доор, доод тогтоогчийг баруун энгэрийн бартаа (Онцгой байдлын байгууллагын ёслолын хувцасны дээрээсээ 2 дахь товчинд)-ны ард тогтооно.

5.6. Одон, медаль, тэмдэг, тэдгээрийн тууз зүүх:

5.6.1. Одон, медаль, тэмдгийг ёслол-жагсаалын байдлаар ёслолын китель өмссөн үед зүүн энгэрт, захны бартааны өнцгийн түвшнээс (Онцгой байдлын байгууллага ёслолын кителийн зүүн энгэрт эхний товчны доод ирмэгийн түвшнээс) эхлэн баруунаас зүүн тийш зэрэгцүүлэн зүүнэ. Эгнээ хооронд 5 мм-с багагүй зайтай байна.

5.6.2. Монгол Улсын баатрын "Алтан таван хошуу" болон Хөдөлмөрийн баатрын "Алтан соёмбо" тэмдэг, Сүхбаатарын одон: Ёслолын кителийн зүүн энгэрт бусад одон, медалийн дээр, албаны китель дээр одон, медалийн туузын дээр тус тус зүүнэ.

5.6.3. Ардын болон гавьяат цол, Төрийн шагналын тэмдгийг ёслолын болон албаны кителийн баруун энгэрт төгссөн сургуулийн энгэрийн тэмдэг болон бусад тэмдгийн дээд талд зүүнэ.

5.6.4. Хүндэт тэмдгийг захны бартааны өнцгийн түвшинд, салбарын тэргүүний ажилтан тэмдгийг сүүлд төгссөн сургуулийн тэмдэгтэй зэрэгцүүлэн, ёслолын болон албаны кителийн баруун энгэрт зүүнэ. Албаны китель дээр спортын мастерын тэмдгийг сүүлд төгссөн сургуулийн тэмдэгтэй зэрэгцүүлэн зүүж болно.

5.6.5. Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын дурсгалын тэмдгийг цэргийн дүрэмт хувцас дээр зүүхгүй.

5.6.6. Одон, медаль, тэмдгийн туузыг баталгаажсан өнгө, загварын дагуу даавуун материалаар хийлгэж хэрэглэнэ.


5.6.7. Ёслол-амралтын байдлаар ёслолын китель өмссөн үед одон, медаль, тэмдгийн туузын доод ирмэг нь нэрийн тэмдгийн доод ирмэгийн түвшинд байхаар зүүн энгэрт голлуулан зүүнэ.

5.6.8. Албаны китель дээр одон, медалийн тууз зүүх ба доод ирмэгийг зүүн халаасны тагны дээд ирмэгт тулгаж, голлуулан зүүнэ.

5.6.9. Одон, медаль, тэмдгийн туузыг дараах тогтоосон хэмжээнд зүүнэ.

- 1 ширхэг тууз 10x25 мм хэмжээтэй байна;

- 1-4 одон, медаль, тэмдгийг нэг эгнээ туузаар, 5-ыг дээд эгнээнд 4, доод эгнээнд 1-ээр, 6-г дээд эгнээнд 4, доод эгнээнд 2-оор, 7-г дээд эгнээнд 4, доод эгнээнд 3-аар, 8-г 4-өөр 2 эгнээгээр, 9-ийг 4-өөр 2 эгнээ, доод эгнээнд 1-ээр, 9-өөс дээш одон, медаль, тэмдгийг эгнээ бүрд 4, бусдыг доод эгнээнд голлуулж зүүнэ. 20-оос дээш бол тогтоосон эрэмбийн дагуу эхний 20 одон, медаль, тэмдгийн туузыг 5 эгнээгээр зүүнэ.



- Зэрэгцээ тууз бүр 1 мм өргөнтэй хар туузан заагтай байна;

5.7. Сургууль төгссөн тэмдэг: Сүүлд төгссөн сургуулийн тэмдгийг зүүх ба ёслолын китель дээр тэмдгийн доод ирмэгийг энгэрийн дээд товчны төвийн байрлалаас дээш 50 мм зайд, баруун энгэрийг голлуулж зүүнэ. Албаны китель дээр баруун энгэрийн халаасны тагны дээд талд, халаасны товчийг голлуулан, доод үзүүрийг нэрийн тэмдэг (хуванцар)-т тулгаж зүүнэ.

5.8. Нэрийн тэмдэг (хуванцар): Ёслолын кителийн баруун энгэрт сургууль төгссөн тэмдгийн доод ирмэгт тулган зүүнэ. Албаны китель, албаны хүрэм, (онцгой байдлын байгууллагын ёслолын китель)-ийн баруун энгэрийн халаасны тагны дээд ирмэгт нэрийн тэмдгийн доод ирмэгийг тулган голлуулж зүүнэ. Нэрийн тэмдэг нь 80 мм урт, 15 мм өргөн суурин дээр эцэг (эх)-ийн нэрийн эхний үсэг, нэрийг том кирилл (arial фонт), олон улсын арга хэмжээ, гадаад улсад явагдах сургалт, энхийг дэмжих ажиллагаанд нэрийг том латин (arial фонт) дармал үсгээр тус тус 8 мм өндөр, цагаан өнгөөр бичсэн байна.

5.9. Анги, байгууллагын ялгах тэмдэг (төмөр)-ийг албаны кителийн энгэрийн баруун халаасыг голлуулж, хар (хар хүрэн) өнгийн савхин суурин дээр товчноос унжуулан зүүнэ.

5.10. Мэргэжлийн зэргийн тэмдэг (төмөр, хатгамал): Албаны болон хээрийн кителийн энгэрийн зүүн халаасыг голлуулж зүүнэ.

5.11. Байгууллагын ялгах тэмдэг (хатгамал): Албаны болон ёслолын китель, албаны хүрэм, албаны дулаан хүрэм, хээрийн китель, хээрийн хүрэм, өвлийн хээрийн хүрмийн зүүн ханцуйны мөрний залгаа оёдлоос доош 120 мм зайд, ёслолын, албаны богино ханцуйтай цамц, захтай футболкны зүүн ханцуйны мөрний залгаа оёдлоос доош 70 мм зайд тус тус тогтооно.


5.12. "MONGOLIA" тэмдэг (хатгамал): Албаны болон ёслолын китель, богино ханцуйтай цамц дээрх байгууллагын ялгах тэмдэг (хатгамал)-ээс дээш 10 мм зайд тогтооно.

5.13. Анги, байгууллагын ялгах тэмдэг (хатгамал): Албаны болон ёслолын китель, албаны хүрэм, албаны дулаан хүрэм, хээрийн китель, хээрийн хүрэм, өвлийн хээрийн хүрмийн баруун ханцуйны мөрний залгаа оёдлоос доош 120 мм зайд, ёслолын, албаны богино ханцуйтай цамц, захтай футболкны баруун ханцуйны мөрний залгаа оёдлоос доош 70 мм зайд тус тус тогтооно.

5.14. "Улс, байгууллагын ялгах нэр" тэмдэг (хатгамал): Хээрийн хувцасны зүүн энгэрт, халаасны дээд ирмэгт тэмдгийг оёж (нааж) тогтооно. Байгууллага, төрлийн цэргийн командлал, бүсийн нэр байна.

5.15. Цусны бүлэг тодорхойлсон тэмдэг (хатгамал): Тэмдгийн дээд ирмэгийг хээрийн хувцасны зүүн ханцуйны зангууны дээд ирмэгт тулган 25 мм өргөн, 70 мм урт суурин дээр, том латин дармал, хар (хар саарал) өнгийн хатгамал үсгээр цусны бүлгийн олон улсын ангиллаар (резус факторын хамт) тодорхойлж бичнэ.

5.16. Нэрийн тэмдэг (хатгамал): Нэрийн тэмдгийн доод үзүүрийг хээрийн хувцасны баруун энгэрт голлуулан хадна. Нэрийн тэмдгийн өндөр нь 25 мм, өргөн нь 12-16 мм урттай, хар (хар саарал) өнгийн хатгамалтай байна. Эцэг (эх)-ийн



нэрийн эхний үсэг, нэрийг том кирилл (arial фонт), олон улсын арга хэмжээ, гадаад улсад явагдах сургалт, энхийг дэмжих ажиллагаанд нэрийг том латин (arial фонт) дармал үсгээр тус тус бичнэ.

5.17. Цэргийн мэргэжлийн ялгах тэмдэг: Эзэмшсэн мэргэжлийн ялгах тэмдгийг хээрийн хувцасны баруун энгэрт нэрийн тэмдэг (хатгамал)-ээс дээш 10 мм зайд голлуулан зүүнэ. Тэмдэг нь 25 мм өндөр, 35 мм өргөн хэмжээтэй байна.

5.18. Цолны тэмдэг (Хүснэгт 3, Хүснэгт 4, Хүснэгт 5): Дээд офицерын мөрдэсний цолны тэмдэг алтан өнгийн металл (саан) утсан хатгамалтай, цолны тэмдгийн хүрээ нь улаан утсан эмжээртэй байна. Офицер, ахлагчийн ёслолын мөрдэсний цолны тэмдэг мөнгөлөг саарал өнгийн металл, албаны мөрдэсний цолны тэмдэг алтан шар өнгийн металл, хээрийн мөрдэсний цолны тэмдэг хар (ногоон) өнгийн хатгамал байна. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн хээрийн мөрдэсний цолны тэмдэг нь хатгамал (шар, цэнхэр, ногоон) байна.

5.19. Ялгах тэмдэг: Ёслолын болон албаны мөрдэсний ялгах тэмдэг металл, хээрийн мөрдэсний ялгах тэмдэг хатгамал байна.

5.20. Мөрдэсний товч: Ёслолын болон албаны мөрдэсд кнопоор түгжигддэг 17 мм диаметртэй металл товч байна.

5.21. Ёслолын мөрдэс: Ёслолын китель дээр зүүж хэрэглэнэ. 55x125 мм, 55x135 мм, 55x145 мм-ийн хэмжээтэй шар саан мөрдэс байна.

5.22. Албаны мөрдэс: Албаны китель, албаны хүрэм дээр зүүж хэрэглэнэ. 55x125 мм, 55x135 мм, 55x145 мм-ийн хэмжээтэй мөрдэс байна.

5.23. Цамцны мөрдэс: Ёслолын, албаны цамц өмссөн үед ноосон цамц (сүлжмэл)-ыг албаны хүрмийн дотор өмссөн үед зүүж хэрэглэнэ. 50x105 мм-ийн хэмжээтэй мөрдэс байна.


5.24. Хээрийн мөрдэс: Хээрийн хувцас, захтай футболк, ноосон цамц (сүлжмэл), хээрийн дулаан цамц, өмссөн үед зүүж хэрэглэнэ. 50x105 мм-ийн хэмжээтэй даавуун мөрдэс байна.

5.25. Савхин мөрдэс: Савхин дээл өмссөн үед зүүж хэрэглэнэ. Шар өнгийн утсан хатгамалтай, 50x105 мм-ийн хэмжээтэй савхин мөрдэс байна.

Зургаа. Алба хаагч, бэлтгэл үүрэгтний үүрэг, хариуцлага

6.1. Алба хаагч, бэлтгэл үүрэгтэн энэ дүрмийг мөрдлөг болгон, цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг биедээ тохируулж, бүрэн бүтэн, ариг гамтай эдэлж, зориулалтын дагуу цэвэр үзэмжтэй өмсөж хэрэглэх, бэлэн байлгах, эдэлгээний хугацаа, өөрийн хувцасны өмсгөл, хэмжээг мэддэг байх үүрэгтэй.

6.2. Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг дүрмийн дагуу өмсөж, хэрэглэж байгаа байдалд бүх шатны захирагч (дарга) хяналт тавьж, энэ дүрмийг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлыг захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч (төрийн цэргийн байгууллагын ар тал, хангалт хариуцсан албан тушаалтан), хувцасны хангалтын албаны дарга нар хариуцна.



6.3. Цэргийн албанаас халагдсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагч эдэлгээний хугацаа дуусаагүй цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн үнийг төлнө.

6.4. Эдэлгээний хугацаа дуусаагүй цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн үнийг нормоор тогтоосон хугацаанаас дүрэмт хувцас эдэлсэн хугацааг хасаж, тухайн хувцас хэрэглэлийг ордогод авсан дансны үнийн хувь хэмжээгээр тооцож төлүүлэх ба төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, хувцасны хангалтад зарцуулж болно.

6.5. Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн төлбөр, тооцоог бүрэн хийж дууссан тохиолдолд тухайн алба хаагчид холбогдох баримт бичиг, бусад материалыг олгоно.

6.6. Сайн дурын үндсэн дээр биелүүлээгүй тохиолдолд Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль, Иргэний хуулийг үндэслэн цэргийн анги, байгууллагаас иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, цэргийн эд хөрөнгийн хохирлыг барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7. Эмэгтэй алба хаагч үсээ мөрнөөс дээш шууж, хар өнгийн боолтоор бооно.

6.8. Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед нар, салхи, шорооноос хамгаалсан нүдний шил зүүхийг зөвшөөрнө.

6.9. Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг өмсөж хэрэглэхэд дараах зүйлийг хориглоно:

6.9.1. цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг урлаг, уран сайхны кино, хошин хөтөлбөр зэрэг арга хэмжээнд зөвшөөрөлгүй ашиглах, ашиглуулах;

6.9.2. цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг бусдад шилжүүлэх, бэлэглэх, хэрэглүүлэх, түрээслэх, худалдах, өнгө, загвар, стандартыг өөрчлөх, өөр хооронд нь буюу энгийн хувцастай хольж өмсөх;

6.9.3. гадаад улсын цэргийн дүрэмт хувцас өмсөж, хэрэглэх;

6.9.4. үс, хумсыг хурц, тод өнгөөр будах, үсийг дух, нүд, шанаа, хацар, мөр дагуу унжуулах, этгээд маягаар засуулах;


6.9.5. хэт том, хурц өнгөтэй гинж, ээмэг, бөгж, зүүлт, бугуйвч зэрэг гоёл чимэглэл, шашны зан үйлтэй холбоотой эд зүйл зүүж хэрэглэх;

6.9.6. ёслол болон албаны хувцас өмссөн үед үүргэвч үүрэх.

6.10. Энэ дүрэмд зааснаас бусад байгууллага, иргэн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг өмсөж хэрэглэх, тэдгээрийн загварыг ашиглах, үйлдвэрлэхийг хориглоно.

Долоо. Бусад


7.1. Энэ дүрмийг зөрчсөн, цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг худалдан борлуулсан, бэлэглэсэн, барьцаанд өгсөн алба хаагч, бэлтгэл үүрэгтэнд холбогдох хууль, дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



7.2. Цэргийн дүрэмт хувцсыг энэ дүрмийн 1.2-т зааснаас бусад байгууллага, иргэн өмсөж, хэрэглэсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.


7.3. Энэ дүрмийн 1.2-т заасан байгууллагын саналаар энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

---oOo---



ДУЛААНЫ УЛИРАЛ БОЛОН СЭРҮҮНИЙ ҮЕД ӨМСӨХ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН НЭР, ТӨРӨЛ

д/д	Хувцасны нэр, төрөл	Ёслолын хувцас, хэрэглэл	Албаны хувцас хэрэглэл	Хээрийн хувцас, хэрэглэл
1	Малгай	-Ёслолын малгай	-Албаны малгай -Берет малгай -Саравчтай малгай -Майхан малгай	-Хээрийн малгай -Берет малгай
2	Мөрдэс	-Ёслолын мөрдэс -Цамцны мөрдэс -Савхин мөрдэс	-Албаны мөрдэс -Цамцны мөрдэс -Савхин мөрдэс	-Хээрийн мөрдэс
3	Хувцас	-Ёслолын китель, өмд (эмэгтэй алба хаагч юбка) -Ёслолын цамц (урт, богино ханцуйтай) -Хавар намрын пальто (дээд офицер) -Савхин дээл -Борооны цув	-Албаны китель, өмд, юбка -Албаны хүрэм -Албаны цамц (урт, богино ханцуйтай) -Ноосон цамц (сүлжмэл) -Захтай футболк -Футболк -Гурвалжин захтай майк (нэхмэл) -Савхин дээл -Хавар намрын пальто (дээд офицер) -Борооны цув	-Хээрийн китель, өмд -Ноосон цамц (сүлжмэл) -Футболк -Захтай футболк -Хээрийн дулаан цамц -Хээрийн дотуур цамц -Хээрийн хүрэм, өмд -Борооны цув
4	Ороолт зангиа, бээлий	-Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл) -Ёслолын зангиа -Бээлий	-Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл) -Албаны зангиа	
5	Бүс	-Өмдний тэлээ -Саан бүс	-Өмдний тэлээ	-Тактикийн бүс
6	Оймс, гутал	-Зуны гутал -Даавуун оймс	-Зуны гутал -Даавуун оймс	-Хээрийн гутал -Даавуун оймс
7	Ялгах тэмдэг	-Малгайн тэмдэг -Малгайн сагалдарга -Саан зүүлт -Байгууллагын ялгах тэмдэг -Анги байгууллагын ялгах тэмдэг -Нэрийн тэмдэг (хуванцар) -Зангианы хавчаар -"MONGOLIA" тэмдэг (хатгамал) -Сүүлд төгссөн сургуулийн тэмдэг	-Малгайн тэмдэг -Малгайн сагалдарга -Нэрийн тэмдэг (хуванцар) -Сүүлд төгссөн сургуулийн тэмдэг -Зангианы хавчаар -Байгууллагын ялгах тэмдэг -Анги байгууллагын ялгах тэмдэг -"MONGOLIA" тэмдэг (хатгамал) -Захны таних тэмдэг (металл)	-Нэрийн тэмдэг (хатгамал) -"Улс, байгууллагын ялгах нэр" тэмдэг (хатгамал) -Цусны бүлэг тодорхойлсон тэмдэг (хатгамал) -Байгууллагын ялгах тэмдэг -Анги байгууллагын ялгах тэмдэг (хатгамал)



ХҮЙТНИЙ УЛИРАЛД ӨМСӨХ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН НЭР, ТӨРӨЛ

Д/д	Хувцасны нэр төрөл	Ёслолын хувцас, хэрэглэл	Албаны хувцас хэрэглэл	Хээрийн хувцас, хэрэглэл
1	Малгай	- Өвлийн малгай	- Өвлийн малгай	- Ноосон малгай, хоолойвч
2	Мөрдэс	- Ёслолын мөрдэс - Албаны мөрдэс - Цамцны мөрдэс - Савхин мөрдэс	- Албаны мөрдэс - Цамцны мөрдэс - Савхин мөрдэс	- Хээрийн мөрдэс
3	Хувцас	- Ёслолын китель, өмд (эмэгтэй алба хаагч юбка) - Ёслолын цамц (урт, богино ханцуйтай) - Гурвалжин захтай майк (нэхмэл) - Өвлийн пальто (эрэгтэй, эмэгтэй) - Савхин дээл	- Албаны китель, өмд, юбка - Албаны хүрэм - Албаны цамц (урт, богино ханцуйтай) - Ноосон цамц (сүлжмэл) - Захтай футболк - Футболк - Гурвалжин захтай майк (нэхмэл) - Өвлийн пальто (эрэгтэй, эмэгтэй) - Савхин дээл	- Хээрийн китель, өмд - Ноосон цамц (сүлжмэл) - Футболк - Хээрийн дулаан цамц - Хээрийн дотуур цамц - Өвлийн хээрийн хүрэм, өмд
4	Ороолт, зангиа, бээлий	- Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл) - Ёслолын зангиа - Савхин бээлий	- Хүзүүний ороолт (ноолуур, сүлжмэл) - Албаны зангиа - Савхин бээлий	- Савхин бээлий
5	Бүс	- Өмдний тэлээ - Саан бүс	- Өмдний тэлээ - Тактикийн бүс	- Тактикийн бүс
6	Гутал, оймс	- Өвлийн гутал - Ноосон оймс	- Өвлийн гутал - Ноосон оймс	- Хээрийн гутал - Ноосон оймс
7	Ялгах тэмдэг	- Малгайн тэмдэг - Малгайн сагалдарга - Саан зүүлт - Байгууллагын ялгах тэмдэг - Анги байгууллагын ялгах тэмдэг - Нэрийн тэмдэг (хуванцар) - Зангианы хавчаар - "MONGOLIA" тэмдэг (хатгамал) - Сүүлд төгссөн сургуулийн тэмдэг - Зангианы хавчаар	- Малгайн тэмдэг - Малгайн сагалдарга - Нэрийн тэмдэг (хуванцар) - Сүүлд төгссөн сургуулийн тэмдэг - Зангианы хавчаар - Байгууллагын ялгах тэмдэг - Анги байгууллагын ялгах тэмдэг - "MONGOLIA" тэмдэг (хатгамал) - Захны таних тэмдэг (металл)	- Нэрийн тэмдэг (хатгамал) - "Улс, байгууллагын ялгах нэр" тэмдэг (хатгамал) - Цусны бүлэг тодорхойлсон тэмдэг (хатгамал) - Байгууллагын ялгах тэмдэг - Анги байгууллагын ялгах тэмдэг (хатгамал)




ЦОЛНЫ ТЭМДГИЙН ТАЙЛБАР

Офицерын таван хошуу нь 5 тивийг билэгдэж, тал бүр тийш чиглэх сумны зэв нь дайснаас улс орноо хамгаалах утгыг;

Ахлах офицерын ялгах тэмдэг нь шулуун шударга журамтай гэсэн утгатай бөгөөд хүн бүхэн Монгол Улсынхаа төлөө цэх шударга нэгэн үзүүрт сэтгэл зүтгэлээр хүчээ өгтүгэй гэсэн утгыг;


Ахлагчийн цолны тэмдгийн гурвалжин дүрс нь ардаа гичиртэй, хажуугаас нь харвал татсан нум сумны хэлбэртэй бөгөөд энэ нь "Харвахад бэлэн" гэсэн утгыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл ахлагч нар нь "Харвахад бэлэн сум" гэсэн утгыг;

Зураас нь сургагч ахлагч болон тэргүүн ахлагч дээр зүүх ба удирдах албан тушаалыг тодорхойлж, өөрийн удирдлагад байгаа гүйцэтгэх албан тушаалын ахлагч нарыг удирдан чиглүүлнэ гэсэн утгыг;




ДЭЭД ОФИЦЕРЫН МӨРДЭСНИЙ ЦОЛНЫ ТЭМДГИЙН БАЙРЛАЛ

Д/д	Цэргийн цол	Цолны тэмдгийн өнгө	Цолны тэмдгийн хэлбэр	Цолны тэмдгийн материал	Цолны тэмдгийн хэмжээ		Цолны тэмдгийн тоо	Мөрдэсний мөрен талын эхлэн хэмжих шугамаас тэмдгийн төв, туузын гол хоорондын зай цувраагаар /мм/	Мөрдэсний урт, өргөн /мм/
					Урт /мм/	Өргөн /мм/			
Нэг. Ёслолын мөрдэс									
1	Генерал	Шар	Таван хошуу	Саан утсаар товойлгож оёсон гар хатгамал	20	20	4	30	125/55
2	Дэслэгч генерал	Шар	Таван хошуу		20	20	3	30	125/55
3	Хошууч генерал	Шар	Таван хошуу		20	20	2	30	125/55
4	Бригадын генерал	Шар	Таван хошуу		20	20	1	45	125/55
Хоёр. Албаны болон									
1	Генерал	Шар	Таван хошуу	Саан утсаар товойлгож оёсон гар хатгамал	20	20	4	30	125/55
2	Дэслэгч генерал	Шар	Таван хошуу		20	20	3	30	125/55
3	Хошууч генерал	Шар	Таван хошуу		20	20	2	30	125/55
4	Бригадын генерал	Шар	Таван хошуу		20	20	1	45	125/55
Гурав. Хээрийн болон цамцны мөрдэс									
1	Генерал	Шар	Таван хошуу	Саан утсаар товойлгож оёсон хатгамал	20	20	4	22	100/55
2	Дэслэгч генерал	Шар	Таван хошуу		20	20	3	30	100/55
3	Хошууч генерал	Шар	Таван хошуу		20	20	2	30	100/55
	Бригадын генерал	Шар	Таван хошуу		20	20	1	45	100/55



ОФИЦЕР, АХЛАГЧИЙН МӨРДЭСНИЙ ЦОЛНЫ ТЭМДГИЙН БАЙРЛАЛ

д/д	Цэргийн цол	Цолны тэмдгийн өнгө	Цолны тэмдгийн хэлбэр	Цолны тэмдгийн материал	Цолны тэмдгийн хэмжээ		Цолны тэмдгийн тоо	Мөрдэсний мөрөн талын эхлэн хэмжих шугамнаас тэмдгийн төв, туузны гол хоорондын зай цувраагаар /мм/	Мөрдэсний урт, өргөн /мм/	
					Урт /мм/	Өргөн /мм/				
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Ёслолын хувцасны мөрдэс										
1	Хурандаа		Том таван хошуу Ялгах тэмдэг	Металл	21	21	3	35	60	85
2	Дэд хурандаа		Том таван хошуу Ялгах тэмдэг		45	5	2	5	12	-
3	Хошууч		Том таван хошуу Ялгах тэмдэг		21	21	3	35	60	-
4	Ахмад		Том таван хошуу Ялгах тэмдэг		45	5	2	5	12	-
5	Ахлах дэслэгч		Жижиг таван хошуу Ялгах тэмдэг		21	21	3	35	-	-
6	Дэслэгч	Мөнгөлөг саарал	Жижиг таван хошуу Ялгах тэмдэг		45	5	2	5	12	-
7	Тэргүүн ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		14	14	4	25	45	65
8	Сургагч ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		45	5	2	5	-	-
9	Ахлах ахлагч		Ялгах тэмдэг		21	10	3	45	60	75
10	Ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		21	6	2	25	35	-
11	Дэд ахлагч		Ялгах тэмдэг		21	10	3	35	50	65



125/55
135/55
145/55


1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13		
Албаны хувцасны мөрдэс														
1	Хурандаа	Алтан шар	Том таван хошуу	Металл	21	21	3	35	60	85	-			
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	12	-	-		
2	Дэд хурандаа		Том таван хошуу		21	21	3	3	35	60	-	-		
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	12	-	-		
3	Хошууч		Том таван хошуу		21	21	3	3	35	-	-	-		
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	12	-	-		
4	Ахмад		Жижиг таван хошуу		14	14	4	4	25	45	65	85		
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	-	-	-		
5	Ахлах дэслэгч		Жижиг таван хошуу		14	14	3	3	25	45	65	-		
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	-	-	-		
6	Дэслэгч		Жижиг таван хошуу		14	14	2	2	25	45	-	-		
		Ялгах тэмдэг	45	5	2	2	5	-	-	-				
7	Тэргүүн ахлагч	Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	3	45	60	75	-		125/55 135/55 145/55		
		Ялгах тэмдэг	21	6	2	2	25	35	-	-				
8	Сургагч ахлагч	Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	3	35	50	65	-				
		Ялгах тэмдэг	21	6	1	1	25	-	-	-				
9	Ахлах ахлагч	Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	3	25	40	55	-				
		Ялгах тэмдэг	21	10	2	2	25	40	-	-				
10	Ахлагч	Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	1	1	25	-	-	-				
11	Дэд ахлагч	Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	1	1	25	-	-	-				
Савхин дээлийн мөрдэс														
1	Хурандаа	Шар	Том таван хошуу	Хатгамал	21	21	3	38	58	78	-			
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	12	-	-		
2	Дэд хурандаа		Том таван хошуу		21	21	2	2	38	58	-	-		
			Ялгах тэмдэг		45	5	2	2	5	12	-	-		
3	Хошууч	Том таван хошуу	21	21	1	1	38	-	-	-				
		Ялгах тэмдэг	45	5	2	2	5	12	-	-				
4	Ахмад	Жижиг таван хошуу	14	14	4	4	25	45	65	85				
		Ялгах тэмдэг	45	5	2	2	5	12	-	-				




5	Ахлах дэслэгч		Ялгах тэмдэг Жижиг таван хошуу	45	5	1	5	45	65	-	105/50
6	Дэслэгч		Ялгах тэмдэг	14	14	3	25	45			
			Жижиг таван хошуу	45	5	1	5				
7	Тэргүүн ахлагч		Ялгах таван хошуу	14	14	2	25	45			
			Ялгах тэмдэг	45	5	1	5				
			Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	30	55	70		
8	Сургагч ахлагч	Шар	Тэргүүн ахлагчийн ялгах тэмдэг	21	6	2	10	20			
			Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	20	35	50		
			Сургагч ахлагчийн ялгах тэмдэг	21	6	1	10				
			Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	10	25	40		
9	Ахлах ахлагч			21	10	2	10	25			
10	Ахлагч			21	10	2	10	25			
11	Дэд ахлагч			21	10	1	10				

Цамцны мөрдэс

1	Хурандаа		Том таван хошуу	21	21	3	38	58	78	-	105/50
2	Дэд хурандаа		Ялгах тэмдэг	45	5	2	5	12			
			Том таван хошуу	21	21	2	38	58			
3	Хошууч		Ялгах тэмдэг	45	5	2	5	12			
			Том таван хошуу	21	21	1	38				
			Ялгах тэмдэг	45	5	2	5	12			
4	Ахмад		Жижиг таван хошуу	14	14	4	25	45	65	85	
			Ялгах тэмдэг	45	5	1	5				
5	Ахлах дэслэгч	Шар	Жижиг таван хошуу	14	14	3	25	45	65		
			Ялгах тэмдэг	45	5	1	5				
			Жижиг таван хошуу	14	14	2	25	45			
6	Дэслэгч		Ялгах таван хошуу	45	5	1	5	45			
			Ялгах тэмдэг	45	5	1	5				
7	Тэргүүн ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг	21	10	3	40	55	70		
			Тэргүүн ахлагчийн ялгах тэмдэг	21	6	2	20	30			



8	Сургагч ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		21	10	3	30	45	60	-	
			Сургагч ахлагчийн ялгах тэмдэг		21	6	1	20	-	-	-	
9	Ахлах ахлагч	Шар	Гурвалжин дүрс бүхий тэмдэг	Хатгамал	21	10	3	20	35	50	-	
10	Ахлагч				21	10	2	20	35	-	-	-
11	Дэд ахлагч				21	10	1	20	-	-	-	-
Хээрийн хувцасны мөрдэс												
1	Хурандаа	Хар (ногоон)	Том таван хошуу	Хатгамал	21	21	3	38	58	78	-	
			Ялгах тэмдэг		45	5	12	-	-	-	-	
2	Дэд хурандаа		Том таван хошуу		21	21	2	38	58	-	-	
			Ялгах тэмдэг		45	5	12	-	-	-	-	
3	Хошууч		Том таван хошуу		21	21	1	38	-	-	-	
			Ялгах тэмдэг		45	5	12	-	-	-	-	
4	Ахмад		Жижиг таван хошуу		14	14	4	25	45	65	85	
			Ялгах тэмдэг		45	5	1	5	-	-	-	
5	Ахлах дэслэгч		Жижиг таван хошуу		14	14	3	25	45	65	-	
			Ялгах тэмдэг		45	5	1	5	-	-	-	
6	Дэслэгч		Жижиг таван хошуу		14	14	2	25	45	-	-	
		Ялгах тэмдэг	45	5	1	5	-	-	-			
7	Тэргүүн ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		21	10	3	45	60	75	-	
			Тэргүүн ахлагчийн ялгах тэмдэг		21	6	2	25	35	-	-	
8	Сургагч ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		21	10	3	35	50	65	-	
			Сургагч ахлагчийн ялгах тэмдэг		21	6	1	25	-	-	-	
9	Ахлах ахлагч		Гурвалжин дүрс бүхий тэмдэг		2,1	1,0	3	25	40	55	-	
10	Ахлагч			2,1	1,0	2	25	40	-	-	-	
11	Дэд ахлагч			2,1	1,0	1	25	-	-	-	-	



ГЭРЭЭТ АЛБАНЫ БОЛОН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН МӨРДЭСНИЙ ЦОЛНЫ ТЭМДГИЙН БАЙРЛАЛ

д/д	Цэргийн цол	Цолны тэмдгийн хэлбэр	Цолны тэмдгийн материал	Цолны тэмдгийн хэмжээ	Цолны тэмдгийн тоо	Мөрдэсний мөр талын эхлэн хэмжих шугамнаас тэмдгийн төв, туузны гол хоорондын зай цувраагаар /мм/	Мөрдэсний урт, өргөн /мм/
Цэргийн гэрээт алба хаагчийн хээрийн мөрдэс							
1	Ахлах түрүүч	Зураас	Хатгамал	50	6	35 44 53 62	
2	Түрүүч	Зураас	Хатгамал	50	6	35 44 53	
3	Дэд түрүүч	Зураас	Хатгамал	50	6	35 44	105/50
4	Ахлах байлдагч	Зураас	Хатгамал	50	6	35	
Хугацаат цэргийн алба хаагчийн хээрийн мөрдэс							
1	Ахлах түрүүч	Зураас	Хатгамал	50	6	35 44 53 62	
2	Түрүүч	Зураас	Хатгамал	50	6	35 44 53	
3	Дэд түрүүч	Зураас	Хатгамал	50	6	35 44	105/50
4	Ахлах байлдагч	Зураас	Хатгамал	50	6	35	



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ


ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ ӨМСӨХ КОД

1. Албаны хувцас

№	Нэр, төрөл	Дулааны улирал				Сэрүүний үе		Хүйтний улирал	
		1.1 Албаны китель	1.2 Албаны хүрэм	1.3 Албаны цамц (богино ханцуйтай)	1.4 Захтай футболк	1.1А Албаны китель	1.2А Албаны хүрэм	1.1Б Албаны китель	1.2Б Албаны хүрэм
1. Хувцас, хэрэглэл									
1	Албаны малгай	✓	=	=	x	✓	=	x	x
2	Майхан малгай	x	✓	=	=	=	✓	x	x
3	Берет малгай	=	=	✓	=	=	=	x	x
4	Саравчтай малгай	x	x	=	✓	x	x	x	x
5	Албаны китель	✓	x	x	x	✓	x	✓	x
6	Албаны өмд	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
7	Албаны хүрэм	x	✓	x	x	x	✓	x	✓
8	Албаны цамц (урт ханцуйтай)	✓	x	x	x	✓	x	✓	x
9	Албаны цамц (богино ханцуйтай)	x	x	✓	x	x	x	x	x
10	Захтай футболк	x	x	x	✓	x	x	x	x
11	Футболк	x	✓	x	x	x	✓	x	✓
12	Өмдний тэлээ	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
13	Албаны зангиа	✓	x	x	x	✓	x	✓	x
14	Зуны гутал	✓	✓	✓	✓	✓	✓	x	x
15	Захны таних тэмдэг	✓	✓	x	x	✓	✓	✓	✓
16	Нэрийн тэмдэг (хуванцар)	✓	✓	✓	x	✓	✓	✓	✓
17	Нэрийн тэмдэг (хатгамал)	x	x	x	✓	x	x	x	x
18	Албаны мөрдэс	✓	✓	x	x	✓	✓	✓	✓
19	Цамцны мөрдэс	✓	x	✓	✓	✓	x	✓	x
20	Одон, медаль, тэмдгийн тууз	✓	x	✓	x	✓	x	✓	x
21	Сүүлд төгссөн сургуулийн энгэрийн тэмдэг	✓	x	x	x	✓	x	✓	x
2. Сэрүүний болон хүйтний улиралын хувцас, хэрэглэл									
1	Өвлийн малгай	x	x	x	x	x	x	✓	✓
2	Хавар, намрын пальто	x	x	x	x	✓	✓	x	x
3	Өвлийн пальто	x	x	x	x	x	x	✓	✓
4	Савхин дээл (цегейк, каракуль захтай)	x	x	x	x	✓ (захгүй)		✓ (захтай)	
5	Албаны дулаан хүрэм	x	x	x	x	✓	✓	✓	✓
6	Гурвалжин захтай майк (нэхмэл)	x	x	x	x	✓	x	✓	x
7	Ноосон цамц (сүлжмэл)	x	x	x	x	x	x	✓	x
8	Хүзүүний ороолт	x	x	x	x	✓	x	✓	x
9	Савхин бээлий	x	x	x	x	✓	x	✓	x
10	Өвлийн гутал	x	x	x	x	x	x	✓	x

Тайлбар:

- ✓ - Тэмдэглэгээтэй хувцас, хэрэглэлийг өмсөж хэрэглэнэ.
- x - Тэмдэглэгээтэй хувцас, хэрэглэлийг өмсөхгүй.
- >x - Тэмдэглэгээтэй хувцасны аль нэгийг өмсөнө.
- = - Захирагч (дарга)-ийн шийдвэрээр өмсөж болно.



2. Ёслолын хувцас

№	Нэр, төрөл	Дулааны улирал		Сэрүүний үе		Хүйтний улирал	
		2.1 Ёслол- жагсаал	2.2 Ёслол- амралт	2.1А Ёслол- жагсаал	2.2А Ёслол- амралт	2.1Б Ёслол- жагсаал	2.2Б Ёслол- амралт
1	Ёслолын малгай	✓	✓	✓	✓	х	х
2	Өвлийн малгай	х	х	х	х	✓	✓
3	Ёслолын китель	✓	✓	✓	✓	✓	✓
4	Ёслолын өмд, юбка	✓	✓	✓	✓	✓	✓
5	Ёслолын цамц (богино ханцуйтай)	х	✓	х	✓	х	✓
6	Ёслолын цамц (урт ханцуйтай)	✓	х	✓	х	✓	х
7	Хавар, намрын пальто	х	х	✓	✓	х	х
8	Өвлийн пальто	х	х	х	х	✓	✓
9	Савхин дээл (цегейк, каракуль захтай)	х	х	✓ (захгүй)		✓ (захтай)	
10	Гурвалжин захтай майк (нэхмэл)	х	х	✓	✓	✓	✓
11	Хүзүүний ороолт	х	х	✓	✓	✓	✓
12	Савхин бээлий	х	х	✓	✓	✓	✓
13	Бээлий	✓	х	х	х	х	х
14	Оймс	✓	✓	✓	✓	✓	✓
15	Өмдний тэлээ	✓	✓	✓	✓	✓	✓
16	Ёслолын зангиа	✓	✓	✓	✓	✓	✓
17	Ёслолын мөрдэс	✓	✓	✓	✓	✓	✓
18	Цамцны мөрдэс	✓	✓	✓	✓	✓	✓
19	Саан зүүлт	✓	х	✓	х	✓	х
20	Саан бүс	✓	х	✓	х	✓	х
21	Одон, медаль, тэмдэг	✓	х	✓	х	✓	х
22	Одон, медаль, тэмдгийн тууз	х	✓	х	✓	х	✓
23	Сүүлд төгссөн сургуулийн энгэрийн тэмдэг	✓	✓	✓	✓	✓	✓
24	Зуны гутал	✓	✓	✓	✓	✓	✓
25	Өвлийн гутал	х	х	х	х	х	х

Тайлбар:

- ✓ - Тэмдэглэгээтэй хувцас, хэрэглэлийг өмсөж хэрэглэнэ.
- х - Тэмдэглэгээтэй хувцас, хэрэглэлийг өмсөхгүй.



3. Хээрийн хувцас

№	Нэр, төрөл	Дулааны улирал		Сэрүүний үе		Хүйтний улирал	
		3.1 Хээрийн китель, өмд	3.2 Захтай футболк	3.1А Хээрийн китель, өмд	3.2А Хээрийн дулаан цамц	3.1Б Хээрийн китель, өмд	3.2Б Хээрийн дулаан цамц
1	Хээрийн малгай	✓	✓	✓	✓	х	х
2	Берет малгай	=	=	=	=	х	х
3	Ноосон малгай, хоолойвч	х	х	=	=	✓	✓
4	Хээрийн китель	✓	х	✓	=	✓	х
5	Хээрийн өмд	✓	✓	✓	✓	✓	✓
6	Захтай футболк	х	✓	х	х	х	х
7	Футболк	✓	х	✓	✓	✓	✓
8	Ноосон цамц (сүлжмэл)	х	х	>>	>>	>>	>>
9	Хээрийн дотуур цамц	х	х	>>	>>	>>	>>
10	Хээрийн дулаан цамц	х	х	>>	✓	>>	✓
11	Тактикийн бүс	✓	✓	✓	✓	✓	✓
12	Хээрийн гутал (зун)	✓	✓	✓	✓	х	х
13	Хээрийн гутал (өвөл)	х	х	х	х	х	х
14	Хээрийн хүрэм, өмд	х	х	✓	✓	х	х
15	Өвлийн хүрэм, өмд	х	х	х	х	х	х

Тайлбар:

- ✓ - Тэмдэглэгээтэй хувцас, хэрэглэлийг өмсөж хэрэглэнэ.
- х - Тэмдэглэгээтэй хувцас, хэрэглэлийг өмсөхгүй.
- >> - Тэмдэглэгээтэй хувцасны аль нэгийг өмсөнө.
- = - Захирагч (дарга)-ийн шийдвэрээр өмсөж болно.

